



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 3 сарын 06 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам”-ыг 1 дүгээр, “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны гэрчилгээ”-ний загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хорооны дарга /П.Дэлгэрнаран/, нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/ нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам батлах тухай” 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

1523010051

Сонгуулийн ерөнхий хорооны
2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

СОНГУУЛИЙН ХОРООДОД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн хороодод ажиллах төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад сонгуулийн хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. “Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтын хөтөлбөр”-ийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга батална.

1.3. Сонгуулийн хууль тогтоомжийн өөрчлөлт, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотойгоор сургалтын хөтөлбөрийг энэ журамд заасны дагуу шинэчлэн баталсан тохиолдолд гэрчилгээ авсан төрийн албан хаагчдыг давтан сургалтад хамруулна.

1.4. Сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалт нь дараах төрөлтэй байна.

- 1.4.1. гэрчилгээ олгох сургалт;
- 1.4.2. арга зүйн давтан сургалт.

Хоёр. Сургалтын удирдлага, зохион байгуулалт

2.1. Сонгуулийн ерөнхий хороо /цаашид Хороо гэх/-ны Тамгын газрын сургалт хариуцсан нэгж нь сургалт зохион байгуулах ажлын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. сургалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэх талаар санал боловсруулах, сургалт зохион байгуулах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

2.1.2. сургалт зохион байгуулах, бэлтгэл хангах асуудлаар бүх шатны нутгийн болон төрийн захиргааны байгууллагын уялдаа холбоог хангах, төрийн албан хаагчдад мэдээлэл, зааварчилгаа өгөх;

2.1.3. сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан албан хаагчдын мэдээллийн санг бүрдүүлж, холбогдох мэдээллийг Хорооны хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчид хүлээлгэн өгөх.

2.2. Сургалт зохион байгуулагдах тухай мэдээллийг холбогдох байгууллагад албан бичгээр урьдчилан мэдэгдэж, Хорооны цахим хуудаст байршуулан нийтэд мэдээлнэ.

Гурав. Сургалтын бүртгэл

3.1. Гэрчилгээ олгох сургалтын бүртгэлийг нээлттэй зохион байгуулна.

3.2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч сургалтад хамрагдах хүсэлтээ “Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан” цахим систем /цаашид “цахим систем” гэх/-д бүртгүүлэх бөгөөд өөрийн мэдээллийг үнэн зөв мэдүүлж, дараах баримт бичгийг хавсаргана.

3.2.1.төрийн захиргааны болон үйлчилгээний албанд томилогдсон шийдвэрийн хуулбар.

3.3.Хүсэлт гаргасан албан хаагчийн бүртгэлийн мэдээлэл, баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд сургалт хариуцсан нэгж энэ тухай мэдэгдэж сургалт зохион байгуулахаас өмнө нөхөн бүрдүүлсэн байна.

3.4.Сургалт хариуцсан нэгж нь гэрчилгээ олгох сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээллийг цахим системээр хүлээн авч, холбогдох баримт бичиг мэдээллийг нягтлан шалгаж, бүртгэлийг баталгаажуулна.

Дөрөв. Сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох

4.1.Энэ журмын 1.4.1-т заасан гэрчилгээ олгох сургалтыг дараах байдлаар зохион байгуулна:

4.1.1.сургалт хариуцсан нэгж батлагдсан хөтөлбөрийн дагуу боловсруулсан хичээлийг цахим системд байршуулна.

4.1.2.энэ журамд заасны дагуу гэрчилгээ олгох сургалтад бүртгүүлсэн албан хаагчид цахим системд байршуулсан хичээлийг бие даан судална.

4.2.Энэ журмын 4.1-т заасны дагуу байршуулсан гэрчилгээ олгох сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу бүрэн судалсан албан хаагчид байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах гэрчилгээ олгоно.

4.3.Гэрчилгээний дугаар нь тухайн албан хаагчийн цахим бүртгэлийн дугаар байх бөгөөд албан хаагчийн мэдээлэл (гэрчилгээний дугаар, овог нэр, ажил албан тушаал)-ийг хорооны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулна.

4.4.Сургалт хариуцсан нэгж нь энэ журмын 1.4.2-т заасан арга зүйн сургалтыг энэ журамд заасны дагуу сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан албан хаагчдад батлагдсан хөтөлбөрийн дагуу цахимаар болон танхимаар зохион байгуулна.

4.5.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороод нь сум, дүүргийн болон хэсгийн хороодод арга зүйн сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу танхимаар болон цахимаар зохион байгуулж болно.

4.6.Энэ журмын 4.5-д заасны дагуу сургалт зохион байгуулахад сургалт хариуцсан нэгж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Тав. Бусад

5.1.Хорооны Тамгын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч сонгуулийн байгууллагын ажилтны сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан төрийн албан хаагчдын мэдээллийн санг шинэчлэх ажлыг хариуцаж, зохион байгуулна.


5.2.Сургалт зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг сонгуулийн төсөвт тусган тухай бүр санхүүжүүлнэ.

Зургаа. Хариуцлага

6.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Сонгуулийн ерөнхий хорооны
2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
15 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



СОНГУУЛИЙН ХОРООДОД АЖИЛЛАХ АЖИЛТНЫ
ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО



ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

.....-ны нь /РД:/
сонгуулийн хороодод ажиллах ажилтны сургалтад хамрагдсан тул
ГЭРЧИЛГЭЭ олгов.

Сонгуулийн ерөнхий хорооны
Дарга /...../ П.Дэлгэрнаран
/тамга/

20 ... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Тайлбар: Гэрчилгээ нь нэгдсэн дугаартай, тусгай нууцлалтай байна.